

**Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
хуулийн төслийн үр нөлөөг тооцох судалгааны тайлан**

2024 он

Товьёг

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ	3
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООХ	4
ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ.....	5
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:	5
3.2. Практикт хэрэгжих боломжтой байдал шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:	Error! Bookmark not defined.
3.3. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал: .	Error! Bookmark not defined.
3.4. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:	8
ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ	12
4.1. Дүгнэлт.....	12
4.2. Зөвлөмж.....	Error! Bookmark not defined.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.1, 17 дугаар зүйлийн 17.1-17.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу хийв.

Хуулийн төслийн үр нөлөөг тооцохдоо тухайн боловсруулж буй хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно. Ийнхүү үнэлгээ хийхдээ “зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авч хийв.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООХ

Шалгуур үзүүлэлт	Хуулийн төслийн зүйл, заалт
Зорилгод хүрэх байдал	<p>1 дүгээр зүйл.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:</p> <p>1/13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг.</p> <p>5.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад газарт Төрийн далбаа байнга мандуулах байршлыг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтоож болно.</p> <p>2/14¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.</p> <p>2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор төрийн далбааг иргэн, хуулийн этгээдэд хүндэтгэлтэйгээр гардуулан өгч болно.</p> <p>2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулья.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Зорилгод дүн шинжилгээ хийх

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:

Шалгуур үзүүлэлт	Хуулийн төслийн зүйл, заалт
Зорилгод хүрэх байдал	<p>1 дүгээр зүйл.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:</p> <p>1/13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг.</p> <p>5.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад газарт Төрийн далбаа байнга мандуулах байршлыг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтоож болно.</p> <p>2/14¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.</p> <p>2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор төрийн далбааг иргэн, хуулийн этгээдэд хүндэтгэлтэйгээр гардуулан өгч болно.</p> <p>2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ.”, Гучдугаар

зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.” гэж заасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөртөө эрхэмлэн хамгаалах үндэсний эв нэгдэл зорилгын хүрээнд ... ард түмнийхээ эв нэгдлийг бэхжүүлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулиар Монгол Улсын Төрийн сүлд, туг, далбаа, тамгыг үйлдэх, дүрслэх, дээдлэн хэрэглэх журмыг хуульчлан зохицуулж байгаа бөгөөд уг хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт төрийн далбааг байнга мандуулах байршлыг хуульчилсан бөгөөд уг хуулийн 25 дугаар зүйлд иргэд, өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь төрийн бэлгэ тэмдгээ гүнээ дээдлэн хүндэтгэж, бүх ард түмний баяр наадам, ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ болон бусад үед Төрийн сүлд, далбаагаа барих байрлуулах, мандуулах буюу Төрийн дууллыг эгшиглүүлж болохоор заасан.

Төрийн далбаандаа хүндэтгэлтэй хандах, түүхт ёс, түүхэн уламжлалаа нандигнан өвлөх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор төрийн далбааг байнга мандуулах эрх зүйн орчинг сайжруулах, түүнчлэн төрийн далбааг иргэн, хуулийн этгээдэд дурсгал болгон хадгалуулах зохицуулалтын хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатай байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан болно
29.1.2. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн байна.
29.1.3. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн байна.

<p>29.1.4. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;</p>	<p>Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн байна.</p>
<p>29.1.5. Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;</p>	<p>Хоорондоо зөрчилдсөн хэсэг байхгүй байна.</p>
<p>29.1.6. Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;</p>	<p>Хуулийн төсөл нь нэг удаагийн болон тунхаг шинжтэй зохицуулалтыг агуулаагүй байна.</p>
<p>29.1.7. Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд ишлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;</p>	<p>Хуулийн төсөл нь энэ шаардлагыг хангасан байна.</p>
<p>29.1.8. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;</p>	<p>Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн байна.</p>
<p>29.1.9. Шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;</p>	<p>Хуулийн төсөл энэ шаардлагыг хангаж байна.</p>
<p>29.1.10. Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт,</p>	<p>Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн байна.</p>

өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	
29.1.11. Хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Энэ хуулийн төсөл нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл тул энэ шаардлагыг хангасан гэж үзнэ.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлагыг хангасан
30.1.2. Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн байна.
30.1.3. Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Хуулийн төсөл ерөнхийдөө шаардлага хангасан.
30.1.4. Хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5. Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

3.4. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судлан, хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдаа уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлуудыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

№	Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
---	-------------------------	--------------------------------

1	Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн байна.
2	Хуулийн төслийн “хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх,	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн байна.
5	Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн байна.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн байна.
7	Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Шаардлагад нийцэж байна.

9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөл энэ шаардлагад нийцсэн байна.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Хуулийн төсөл нь тусгай зөвшөөрөл, аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой төсөл биш болно. Иймд шаардлага хангасан байна.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалтыг тусгасан эсэх	Тусгаагүй тул хамаарахгүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт нь жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Шаардлагыг хангасан.
14	Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Шаардлагыг хангасан. Ийм төрлийн зохицуулалт агуулаагүй болно.
15	Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Шаардлагыг хангасан.

16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт нь тодорхой байгаа болно.
----	---	--

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Дүгнэлт

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг судалж, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын дагуу төслийн үр нөлөөний судалгааг хийж гүйцэтгэлээ.

Хуулийн төсөл нь Төрийн далбаандаа хүндэтгэлтэй хандах, түүхт ёс, түүхэн уламжлалаа нандигнан өвлөх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор төрийн далбааг байнга мандуулах эрх зүйн орчинг сайжруулах, түүнчлэн төрийн далбааг иргэн, хуулийн этгээдэд дурсгал болгон хадгалуулах зохицуулалтын хамрах хүрээг өргөжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгод нийцсэн байна.